



# ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

## 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

# АГУУЛГА



- ХҮНИЙ НӨӨЦ
- ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ
- ШИНЭ САНАА, БҮТЭЭЛЧ АЖИЛ
- БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ
- САНХҮҮ ҮЙЛЧИЛГЭЭ
- ӨРГӨДӨЛ ГОМДОЛ
- СУРГАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА
- ЭРҮҮЛ МЭНД
- БУСАД

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Улсын бүртгэлийн ерөнхий газар  
"Иргэн төвтэй, тэгш хүртээмжтэй төрийн  
цахим үйлчилгээг цогцлооно"




ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХЭРЭГЦЭЭ  
ШААРДЛАГЫГ ХАНГАСАН, ОЛОН УЛСЫН  
ЖИШИГТ НИЙЦСЭН УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛНЭ.

## ХҮНИЙ НӨӨЦ



Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 1-ний өдрийн “Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал зэрэглэлийг шинэчлэн батлах тухай” А/157 дугаар тушаалаар 30 орон тоо батлагдсан.



Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангахаар Сити их сургуулийн эрх зүйн бакалаврын эчнээ ангид 2 албан хаагч, Глобал Удирдагч их сургуульд эрхзүйн бакалаврын эчнээ ангид 1 албан хаагч, Улаанбаатар эрдэм их сургуулийн эрх зүйн эчнээ ангид 1 албан хаагч, Соёл эрх зүйн дээд сургуулийн эрх зүйн эчнээ ангид 1 нийт 5 албан хаагч суралцаж байна. Удирдлагын академийн төрийн албаны дунд шатны мэргэшүүлэх сургалтад 2 албан хаагч хамрагдлаа. Шихихутаг их сургуулийн “Их дээд сургуульд багшлах эрхийн үнэмлэх” олгох сургалтад 1 албан хаагч суралцаж байна.

2025 онд 3 албан хаагч шинээр томилогдож, 3 албан хаагч шилжин томилогдож, 2 албан хаагч ажлаас чөлөөлөгдөж, 1 албан хаагч хүүхэд асрах чөлөө авсан. Мөн 1 албан хаагч төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөсөн.



## ШАГНАЛ

Монгол Улсын Тулгар төрийн 2234 жил, Их Монгол Улсын 819 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 114, Ардын хувьсгалын 104 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан

- “ТӨРИЙН ДЭЭД ШАГНАЛ “ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ” медалиар иргэний улсын бүртгэгч Ишноровын Золжаргал;
- “ХУУЛЬ ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ХУУЛЬ ЗҮЙН АЛБАНЫ ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” тэмдгээр хэлтсийн дарга Дашнямын Оюунбаяр, Хуулийн этгээдийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга Жаргалын Ганзориг, иргэний улсын бүртгэгч Чимэдийн Долгормаа;
- “ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ХҮНДЭТ ЖУУХ БИЧИГ”-ээр эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Намдагийн Гантуяа;
- “УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” цол тэмдгээр иргэний улсын бүртгэгч Бямбаагийн Ганцацрал, иргэний улсын бүртгэгч Ганбаатарын Батгэрэл нар шагнагдлаа



Байгууллагын даргын 2025 оны Б/458 дугаар тушаалаар төрийн захиргааны 3 албан хаагчийн зэрэг дэвийг шинээр, 7 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгосон.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын архив, ажилчдын орон сууцанд хамрагдах хүсэлтэй хэлтсийн 2 албан хаагчдын судалгааг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж, орон сууцны захиалгын гэрээг байгуулсан.

## ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

Улсын бүртгэлийн ерөнхий газар болон хэлтсээс зохион байгуулсан үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг цаг тухай бүр [dornod.burtgel.gov.mn](http://dornod.burtgel.gov.mn), [facebook.com/Ubh.dornod](https://www.facebook.com/Ubh.dornod) цахим хуудаснаа нийтлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд бодлого шийдвэр, цахим үйлчилгээ, улсын бүртгэлийн хууль тогтоомж, цаг үе, үйл явдалтай холбоотой (e-Mongolia-н үйлчилгээ, Иргэний улсын бүртгэл, Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл) 132 мэдээллийг байгууллагын [www.dornod.burtgel.gov.mn](http://www.dornod.burtgel.gov.mn), [https://www.gov.mn/mn/organization/Dornod\\_Ulsiin\\_burtgel\\_kheltes#transparency](https://www.gov.mn/mn/organization/Dornod_Ulsiin_burtgel_kheltes#transparency) цахим сайт [www.facebook.com/Ubh.dornod](https://www.facebook.com/Ubh.dornod) фэйсбүүк /2208 дагагчтай/ хуудсаар тогтмол сурталчилж, цахим хуудасны сэтгэгдэл, захиагаар хандсан 68 иргэнд зохих мэдээлэл, зөвлөгөөг хүргэж ажилласан.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.9 дэх хэсгийн хэрэгжилтийг хангахаар шилэн индекс/[shilen.gov.mn](http://shilen.gov.mn)/-ийн тайланг улирал бүр гарган 100% үнэлүүлсэн.

#	Тайлант үе	Хувиар	Төлөв	Төлөвийн огноо	Илгээсэн хэрэглэгч	Баталгаажсан үнэлгээний хувь	Баталсан мэргэжилтэн	Үйлдэл
1	2025 оны 4 улирал	1	Шилэн	2025-11-07		0%		+ Бөглөх ↓ Тайлан хуулах
2	2025 оны 3 улирал	1	Баталгаажсан	2025-10-02	b.lkhagvazul@burtgel.gov.mn	100%	Э.НОРОВНЯМ	
3	2025 оны 2 улирал	1	Баталгаажсан	2025-07-04	b.lkhagvazul@burtgel.gov.mn	100%	Э.НОРОВНЯМ	
4	2025 оны 1 улирал	1	Баталгаажсан	2025-03-28	b.lkhagvazul@burtgel.gov.mn	99.63%	Э.НОРОВНЯМ	

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 23 дугаар хуралдааны тэмдэглэлийн 2.3, 2024 оны 31 дүгээр хуралдааны тэмдэглэлээр төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудас /[www.gov.mn](http://www.gov.mn)/-т мэдээ, мэдээллийг байршуулах, тухай бүр шинэчилж ажиллахыг даалгасан. Иймд хэлтсийн төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас /[www.gov.mn](http://www.gov.mn)/-ыг 2025 оны 07 сарын 04-ний өдөр нээлгэн 2024 оноос эхлэн хэлтсийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл болон нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн нээлттэй мэдээллүүдийг шинэчлэх, нөхөж байршуулан биелэлтийг хүргүүлэн ажилласан.



Байгууллагын “НЭЭЛТТЭЙ УТАС 98-970-970” дугаараас иргэд бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л төрлийн мэдээллийг авах боломжтой бөгөөд 11 сарын байдлаар 1026 иргэд үйлчлүүлсэн байна.



Улсын бүртгэлийн үйлчилгээний “ДӨТ” машинаар нийт 8606 иргэн (гэрлэсний бүртгэлийн, байнга оршин суугаа хаягийн, иргэний цахим үнэмлэхийн, эд хөрөнгөтэй эсэх гэх мэт) лавлагаа үйлчилгээг авсан байна.

“ГАДААД ПАСПОРТ ЗАХИАЛГЫН ЦАХИМ МАШИН”-аар 1043 иргэн үндэсний энгийн цахим гадаад паспорт захиалсан.

Улсын бүртгэлийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, түргэн шуурхай, хүртээмжтэй болгох чиглэлээр үйлчилгээний төлбөр, хураамжийг боловсронгуй болгох, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх зорилгоор ГЭРЭГЭ КИОСК машинаар тайлант хугацаанд 20992 иргэнд үйлчлүүлсэн байна.

Ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор байгууллагын ухаалаг самбарт мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулж ажиллав.

### АВЛИГА

Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах зорилгоор “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарт мэдээллийг тухай бүр шинэчлэн ажилласан.

АТГ-ын албан ёсны цахим хуудсанд тавигдсан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх уриалга бүхий 18 мэдээллийг байгууллагын цахим хуудас [dornod.burtgel.gov.mn](http://dornod.burtgel.gov.mn) сайт болон Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс фейсбүүк хуудасны дагагч болох 2208 иргэдэд түгээн сурталчлан ажиллав.

Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, авлигын нөхцөлийг бууруулах иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр албан хаагчдын ажлын хувцаслалтыг жигдрүүлж, ажлын үнэмлэх, бүрдүүлэх бичиг баримтын мэдээллийн самбарыг шинэчилсэн.



# ШИНЭ САНАА, БҮТЭЭЛЧ АЖИЛ

## “ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ” ВИДЕО МЭДЭЭЛЭЛ ЦУВРАЛААР ХҮРГЭЖ АЖИЛЛАЛАА.


Улсын бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор “Та үүнийг мэдэх үү” видео мэдээ, мэдээллийг цувралаар хүргэж ажилласан. Мөн төрийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор цахим контентыг дохионы хэлний хадмал орчуулгатай болгож шинэчлэлээ. Үүнд:

- Парт-1:Гадаад паспорт захиалахад хялбар боллоо
- Парт-2:Барьцааны гэрээг шуурхай бүртгэдэг боллоо
- Парт-3:Хуулийн этгээдийн шинээр үүсгэн байгуулах тухай
- Парт-4:Улсын бүртгэлийн үйлчилгээний хугацааны тухай
- Парт-5:Улсын бүртгэлийн 18 төрлийн лавлагааг өөртөө үйлчлэх ДӨТ машинаас авах тухай
- Парт-6:Гэрэгэ киоск машинаар улсын бүртгэлийн үйлчилгээний төлбөрийг төлөх тухай
- Парт-7:Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг цахимаар бүртгүүлэх тухай
- Парт-8:Иргэний үнэмлэхийн бүртгэлийн тухай
- Парт-9:Гэрлэлтийн бүртгэлд хэрхэн бүртгүүлэх тухай
- Парт-10:Хил нэвтрэх үнэмлэхийн талаарх мэдээлэл
- Парт-11:E-business сайтаас үйл хөдлөх хөрөнгө(Хуулийн этгээдийн)-ийн лавлагаа авах заавар




## АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГАА

Албан хаагчдын ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэлтсийн байранд засвар үйлчилгээ хийж үйлчилгээний танхим болон хүүхдийн өрөөг тохижуулав.



# БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ


## БИЧИГ ХЭРГИЙН ЭРГЭЛТ



## ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР


Хэлтсийн даргын баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу 2025 онд хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн зөрчил илрүүлэн арилгах, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, бүртгэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилтыг тавьж ажиллалаа. Үүнд:

Ажлын үр бүтээмжийг дээшлүүлэх, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй гүйцэтгэх, мэргэшил ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт туршлага солилцохоор ажиллав.



Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих зорилгоор урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг нийт 1411 бүртгэлд хийв. Үүнээс Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-39, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр-4, хуулийн этгээдийн чиглэлээр-2 зөрчил илэрсэн бөгөөд шууд-, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргаж бүртгэлийн зөрчлийг арилгалаа.


### Урьдчилсан хяналт шалгалт хийсэн бүртгэлийн тоо:





Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын улсын байцаагч Ш.Уртнасангаас ирүүлсэн 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн улсын байцаагчийн албан шаардлагад дурдсан 2 зөрчлийг мэдээллийн санд зөрчлийг арилгаж, илтгэх хуудсыг тогтоосон хугацаанд хүргүүлэн ажиллалаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хийсэн дадлагын хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр хэлтсийн нийт 19 албан хаагчдад “ Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд анхаарах асуудал, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэдээллийн аюулгүй байдал” сэдвээр сургалт зохион байгуулав.



Бүртгэлийн зөрчлийг арилгуулахаар иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 138 өргөдлийг хүлээн авч тухайн шатанд шийдвэрлэн иргэдэд Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрийг утсаар мэдэгдэж, хариу өгч ажилласан. Үүнийг ангилвал: иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-34, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр-94, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр-10 өргөдлийн хүлээн авч, өргөдлийг хууль тогтоомжид заасан хугацаанд бүрэн ханган шийдвэрлэж нийт 138 дүгнэлтийг нотлох баримтад үндэслэн зөрчлийг арилгаж, тухай бүр мэдээллийн санд засвар өөрчлөлтийг тусгуулан ажиллав.

Хууль, захиргааны хэм хэмжээг актыг зөрчсөн нийт 89 иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, зөрчлийн материалыг хуульд заасан хугацаанд прокурорт хянуулж, сар бүрийн 30-ны өдрөөр тасалбар болгон тайлан мэдээг 11 удаа хүргүүлэн ажиллалаа.

# БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ


## ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ

- ХУБ-ийн 2023 оны 4865 нэгдсэн дүгнэлтийн дагуу нэмэлт өөрчлөлтөөр 3539, нөхөн бүртгэл-57, ХУБ-ийн 2021 оны 6839 нэгдсэн дүгнэлтээр 62 иргэний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд засварлаж, зөрчлийг арилгасан.
- УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газраас 2025.01.09-ний өдрийн 3/432 тоот “Иргэний үнэмлэхийн бүртгэл шалгах тухай” албан бичгийн хүрээнд 2024.12.10-ний өдрөөс 2025.01.09-ний өдрийг хүртэлх биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл бүртгүүлсэн 330 иргэний бүртгэлийг шалгаж төрөл буруу сонгосон алдаа байхгүй хариуг хүргүүлсэн.
- УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 3/1017 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг нийт улсын бүртгэгч нарт танилцуулж, хуулбарлан өгч, зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах талаар үүрэг өгөв.
- УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газраас 2025.04.03-ний өдрийн 3/4273 тоот “иргэний e-mongolia.mn системээр дамжуулан шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлэх”-зөвлөмжийг албан бичгийн хүрээнд нийт улсын бүртгэгч нарт танилцуулж, хуулбарлан өгч, биелэлтийг хангаж ажиллах талаар үүрэг өгөв.
- УБЕГазрын даргын 2025 оны 03 дүгээр сарын 28-ны өдрийн 1/4410 тоот албан даалгаврын хүрээнд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр болон лавлагаа олголтын талаарх сургалтыг иргэний улсын бүртгэгч нарт 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулж ажиллалаа.
- УБЕГазрын нэгдсэн архивын газраас 2025.04.09-ний өдрийн 9/4940 тоот “Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх талаар” чиглэлийг нийт улсын бүртгэгч нарт танилцуулж, Дорнод аймгийн хэмжээн Төрсний бүртгэлийг бүртгэсэн он зөрүүтэй 1194, гэрлэсний бүртгэлийн бүртгэсэн он, сар зөрүүтэй 1157, нас барсны бүртгэлийн он, сар зөрүүтэй 808 иргэний мэдээллийг нягтлан шалгаж хяналтын улсын байцаагчийн нэгдсэн дүгнэлтээр 3100 зөрчлийг иргэний мэдээллийн санд арилгаж, 59 зөрчлийг арилгуулахаар ХУБайцаагчид жагсаалтаар гаргаж шилжүүлсэн.
- Хэлтсийн даргаар батлуулсан төлөвлөгөөний дагуу 2000-2023 оны иргэний 40367 ширхэг ИУБМаягт шалган цахимжуулахаас 100 хувийн гүйцэтгэлтэй цахимжуулаад байна.





**Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 21698 бүртгэл бүртгэгдсэн. Үүнийг ангилбал:**



### **ТООН ГАРЫН ҮСЭГ**

Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх “Тоон гарын үсгийн талаарх” сургалтыг 4 төрийн болон төрийн бус байгууллагын 180 гаруй албан хаагчдад хүргэж, зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан. Давхардсан тоогоор 74195 иргэнд тоон гарын үсэг олгосон. /Өссөн дүнгээр/

## БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

### АНСДИТХ-ЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

ИУБГ-аас 2025.04.16-ны өдөр өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу тус аймгийн 2 сумын 3 хэсгийн дугаарыг нягтлан шалгахад давхардал байхгүй бөгөөд сонгуулийн election.gasr.mn программд тусгагдсан тус аймгийн 2 сумын 3 сонгуулийн хэсэгт хамаарах 1516 хаягийн мэдээллийг 2 сумын ИТХТТ-той тулган, нягтлан шалгаж дууссан бөгөөд хэсэг оноолт зөв хийгдсэн байна.

УБЕГазраас ирүүлсэн 2025.04.16-ны өдрийн 2/5282 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу даарах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын бүртгэлийн хэлтэст ирсэн иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 2025.04.22-ны өдрийн 17 цаг 00 минутад сүүлийн бүртгэлийг хөтөлж иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хаасан.
- 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар иргэний бүртгэлийн системээр - 739 иргэн, имонголиагаар – 162 хүсэлтийг хуульд заасан хугацаанд баталгаажуулсан.
- АНСДИТХ-ын сонгуулийн СНЖ-ыг хэвлэх эрхийг улсын ахлах бүртгэгч Ч.Энхцэцэгт нээлгэхээр ИУБГ-т хүргүүлсэн.

2025 оны 05 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд хэлтсийн дарга Д.Оюунбаяраар ахлуулж, улсын ахлах бүртгэгч Ч.Энхцэцэг мэдээлэл технологийн ажилтан Б.Лхагвазул нарын бүрэлдэхүүнтэйгээр Дорнод аймгийн Баяндун сумын 2 хэсгийн хороо, Хөлөнбуйр сумын 1 хэсэгт сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарыг байлцуулан сонгогчийн нэрийн жагсаалтыг хүлээлгэн өгч ажиллав.





## ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн эрх түдгэлзүүлсэн тухай 69 албан бичгээр 254 үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэх, эрх сэргээх тухай 50 албан бичгээр ирүүлсэн албан хүсэлтийг үндэслэн 89 үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг сэргээх бүртгэлийг мэдээллийн санд бүртгэж ажилласан.


“Монголын ипотекийн корпорац”-ийн 2025 оны 25/18, 25/42, 25/43 тоот албан бичгээр “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багц”-ыг тусгай тэмдэглэл хийж бүртгүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч худалдах, худалдан авах гэрээнд / ипотекийн зээл/ тусгагдсан 5 банкны 380 ширхэг эд хөрөнгөнд тусгай тэмдэглэл хийж, мэдээллийн санд бүртгэж хариуг хугацаанд нь хүргүүлж ажиллав.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хууль хяналтын байгууллагад 112 албан бичгээр 165 иргэн, 35 хуулийн этгээдийн лавлагаа хуулбарыг олгож ажилласан. УБЕГ-ын даргын 2023.08.24-ны өдрийн А/1614 тушаалын дагуу 23 газар, 23 үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийг хаах бүртгэлийг мэдээллийн санд бүртгэж ажиллав.

УБЕГ-ын даргын 2020.08.11-ны өдрийн 8/7219 чиглэлийн дагуу ХУБ-ийн дүгнэлтээр үрэгдүүлсэн 70 газар, 16 үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх гэрчилгээг хүчингүйд тооцож шинээр гэрчилгээг бичиж олгосон. УБЕГ-ын ХШГ-ын ХУАБайцаагчийн 2022.03.02-ны өдрийн № 1500 дүгнэлтийг үндэслэн ЭХЭУБ-ийн 80 хувийн хэргийн цахим мэдээллийн санг архивын хувийн хэргийн цаасан нотлох баримттай тулган шалгаж мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулж, мэдээллийн санд баяжилт хийж ажиллав.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 5/529 тоот, 2025 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 5/4982 тоот, 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 5/6125 тоот, 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 5/6824 тоот хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг ханган холбогдох арга хэмжээг авч тайланг тогтоосон хугацаанд албан бичгээр албажуулан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлж ажилласан.

Тайлант хугацаанд нийт 8076 бүртгэлийг бүртгэсэн. Мөн 4 суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрхийг олгож 2025 онд нийт 201 бүртгэл хөтөлсөн.



# БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

## ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ

Тайлант хугацаанд 2664 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зөвлөгөө өгч, мэдээ мэдээллээр ханган ХЭУБ-ийн үйлчилгээг үзүүлсэн бөгөөд “Монгол улсын тэмдэгтийн хураамжийн хууль”-ийн дагуу 19.599 мян.төгрөгийн хураамжийг киоск машинаар улсын болон орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журам, эрх зүйн актын хүрээнд дараах ажил үүргийг гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Хуулийн этгээд байгуулахаар оноосон нэр шинээр авах 403, нэрийн хугацаа сунгах 3, оноосон нэр, хэлбэр өөрчлөх 12 иргэн, аж ахуй нэгжийн хүсэлтийг баталгаажуулав.
- 325 аж ахуйн нэгж, байгууллага шинээр үүсгэн байгуулсан.
- 318 нэр төрлийн нэмэлт өөрчлөлтийг цахим мэдээллийн санд оруулж, шинэчилсэн болон үрэгдүүлсэн, гэмтээсэн /шилжиж ирсэн/ шалтгаанаар 52 аж ахуйн нэгж, байгууллагад дахин гэрчилгээг тус тус олгосон.
- Хуулийн этгээдийн 9 салбар шинээр бүртгэсэн. Дорнод аймагт бүртгэлтэй 7 салбарт нэмэлт өөрчлөлт оруулсан.
- 12 аж ахуйн нэгж, байгууллагыг хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасаж татан буулган, хувийн хэргийг архивлан хэлтсийн архивд шилжүүлсэн. Мөн ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хэлбэр регистр, оноосон нэр өөрчилсөн, татан буугдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын 18 тамгыг хураан авсан.
- Архивын цахим мэдээллийн сангаас 14 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн этгээдэд лавлагаа /тодорхойлолт/ олгож ажилласан.
- 382 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тамганы хяналтын дугаар олгох үйлчилгээ үзүүлсэн.

“Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн төсөлд хэлтсийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн №55, 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн №293 дугаар албан бичгээр тус тус санал хүргүүлсэн. Мөн “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-ын төсөлд тусгуулах саналыг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр ХЭУБГ-т хүргүүлсэн.

Тайлант хугацаанд хэлтсийн даргаас цохогдсон хууль хяналтын байгууллагын 31 албан бичиг, төрийн болон төрийн бус байгууллагын 26 албан бичгийг хүлээн авж, холбогдох арга хэмжээг аван, хариуг хүргүүлэн ажилласан. Төрийн үйлчилгээний систем болох ebusiness.mn сайтад хуулийн этгээдийн 1848 оноосон нэрийн хүсэлтийг мэдээллийн санд шүүж, хариуг хүргүүлж ажилласан.



Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын санд архивч С.Батчимэгтэй хамтран 1 дүгээр улиралд багтаан тооллого хийж дуусгасан. Тооллогын үр дүнд мэдээллийн санд бүртгэлтэй аж ахуй нэгж, байгууллагыг төрөл бүрээр нь цахим сангаас татаж, цаасан нотлох баримттай тулган, улсын бүртгэлээс хасагдсан төлөвтэй болон татан буугдсан төлөвтэй аж ахуй нэгжийн хувийн хэргийг ялгаж, цэгцэлсэн.

Аймгийн Жижиг дунд үйлдвэрийн газраас зарласан жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих зээл, сум хөгжүүлэх сангийн зээл, аймгийн Засаг даргын Тамгын Газраас баталсан “Хүн болох багаасаа” төслийн хүрээнд төслийн тендер, сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй хуулийн этгээдүүдийг тендерийн материалаа нэг цэгээс бүрдүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах “Нэг цэгийн үйлчилгээ”-нд тус тус ажиллаж, 47 аж ахуй нэгжийн бүрдүүлбэрийг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэж ажилласан.

Хэрлэн сумын Засаг даргын Тамгын Газар, Насан туршийн боловсролын төв, Амжилтын хөшүүрэг ТББ байгууллагатай тус тус хамтран гарааны бизнес эрхлэгч иргэдэд зориулсан “Шинээр хуулийн этгээд үүсгэн байгуулахад шаардлагатай бичиг баримтын бүрдүүлбэр”-ийн талаарх сургалтыг 3 удаа зохион байгуулж 61 иргэнийг хамруулсан.



Бүртгэлийн үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, иргэдийн цахим мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор санаачлан “Та үүнийг мэдэх үү?” цуврал 6 видео контентыг бэлтгэсэн. “Гадаад паспорт” 8.5K үзэлттэй, “Барьцааны гэрээ” ний талаарх видео 3.2K үзэлттэй, “E-business” сайтын талаарх видео 6.2K үзэлттэй, “Бүртгэлийн хугацаа”-ны талаарх видео 2.7K үзэлттэй, “Лавлагааны машин”-ы талаарх видео 1.8K үзэлттэй, “Гэрэгэ киоск машин”-ы талаарх видео 7.4K хүн, “Хоршоо шинээр үүсгэн байгуулахад бүрдүүлэх бичиг баримт”-ын талаар видео 4,4K хандалттай, зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн “Гарт-Гэрт” бүртгэлийн үйлчилгээний талаарх хийсэн видео бичлэгийг нь 5,2K хүн тус тус үзэж, 146 хүн хуваалцаж бусдад түгээсэн.

# БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

## ТӨРӨЛЖСӨН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР

Архивд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гарган тасгийн даргаар хянуулж, хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна.

### Иргэний улсын бүртгэлийн тасгийн архив:

Тус архивд 198953 хувийн хэрэг ХААТР маягтууд хадгалагдаж байна. Нийт 5205 ширхэг ХААТР маягтыг иргэний улсын бүртгэгчээс хүлээн авч, архивын сан хөмрөгийн баяжуулалтыг хийсэн. Мөн хяналтын улсын байцаагч болон улсын бүртгэгч нарт 1583 ширхэг хувийн хэрэг татан өгч, аймаг хотоос бүр мөсөн шилжин явсан 275 иргэний хувийн хэргийг хүргүүлэн ажиллалаа.

### Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив:

Тус архивд 50519 хувийн хэрэг хадгалагдаж байна. ЭХЭУБ хөтлөх үйл ажиллагааны явцад бий болсон нэмэлт өөрчлөлтийн 5256 нотлох баримт, шинээр үүсгэсэн газар өмчлөх эрхийн анхны бүртгэл 477 газраас бусад үл хөдлөх ЭХЭУБ 519 хувийн хэргийг архивд хүлээн авч байршуулсан. Мөн бүртгэлийн үйл явцад шалгах шаардлагатай 243 хувийн хэргийг улсын ахлах бүртгэгч болон улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгсөн.

Газар болон газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 20200 ширхэг хувийн хэргийг архивын стандартын дагуу бор хайрцагт байршуулсан стандартын дагуу цэгцэлж ажилласан.

### Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архив:

Тус архивд 3391 хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүнээс шинээр үүссэн аж ахуй нэгжийн 290 ширхэг хувийн хэрэг хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэсэн Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээс шаардлага хангахгүй болон хэрэглэх боломжгүй болсон 45 тамгыг хүлээн авсан.


Хадгаламжийн нэгжийн бодит тоог тогтоох, тоо бүртгэлийн баримтад тусгагдсан тоотой тохирч буй эсгэхийг шалгах, механик болон биологийн гэмтлээс сэргийлэх, сэлбэн засах шаардлагатай баримтыг илрүүлэх зорилгоор хуулийн этгээдийн бүртгэлийн цаасан суурьтай эх нотлох баримтад тооллогыг 100 хувь хийж дууссан. Архивын тайлан мэдээг сар бүрийн 25-аар тасалбар болгон үнэн зөв гаргаж холбогдох газарт хугацаанд хүргүүлэн ажилласан.





### Бусад ажил:

УБЕГ-ын Улсын бүртгэлийн нэгдсэн архиваас 2025 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 9/4940 тоот албан бичгийн дагуу Иргэний улсын бүртгэл (1951-1988 оны төрсний, гэрлэсний, гэрлэлт дуусгавар болсны, эцэг /эх/ тогтоосны, үрчилсний, овог /эцэг эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний, нас барсны бүртгэл)-ийн дэвтрийг он болон бүртгэл тус бүрээр жагсаалт үйлдэж нэгдсэн тоог гаргасан. Үүнд:



Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 1/4410 тоот албан даалгаврын хүрээнд Архиваас улсын бүртгэлийн хувийн хэрэг нотлох баримтыг түр олгохдоо хуудасны тоо бичиж олгож, архивд хүлээн авахдаа хуудасны тоо дугаарыг тулгаж гарын үсэг зуруулж ажиллаж байна. Мөн чийг дулааны хэмжилтийг нийт 95 удаа, архивын өрөөний цэвэрлэгээг нийт 16 удаа чийгтэй болон их цэвэрлэгээ хийсэн.

Төрийн байгууллагын архив албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгтэй холбогдуулан Иргэний улсын бүртгэлийн ИГБББ-ын бүрдүүлбэрийг хадгалах хугацааны дагуу Байнга, Түр, 70 жил-ээр ангилан хадгаламжийн нэгжийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалт үйлдсэн.





# БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

## БАЙГУУЛЛАГЫН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 1/11299 албан даалгаврын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- Байгууллагын архивын мэдээллийн самбар болон галын буланг стандартын дагуу шинэчлэв.
- 2020-2024 оны архивын баримт бичгийн цахим санг үүсгэлээ.
- Баримт бичиг нягтлан шалгах комисс, хэвлэмэл хуудас хариуцах ажилтныг шинээр томилов.
- Бичиг хэргийн ажилтныг албан хэрэг хөтлөлтийн талаарх мэргэшүүлэх сургалтад хамруулав.
- Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, 2025 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг шинэчлэн батлав.





## САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд 1,079,066,800 төгрөгийн төсөвтэйгөөр үйл ажиллагаа явуулж 1,079,066,800 төгрөгийн буюу 100% төсвийн гүйцэтгэлтэй ажилласан. Улсын төсөвт 243,230,810.35 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.


Төсвийн гүйцэтгэлийн мэдээг, үнэт цаас зарцуулалтын тайланг хуулийн хугацаанд УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэст хүргүүлсэн.

Бараа материал худалдан авах зорилгоор 5 аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан, худалдан авалтад 18,138,504 төгрөгийг зарцуулсан.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), байгууллагын [www.ubh.dd.gov.mn](http://www.ubh.dd.gov.mn) сайтад 171 мэдээлэл байршуулж 100% хувийн гүйцэтгэлтэй ажилласан.

Хууль зүй, дотоод хэргийн салбарын санхүү нягтлан бодох бүртгэлийн e-accounting.mojha.gov.mn системд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны мэдээллийг 30%-ийн гүйцэтгэлтэй байршуулж байна.


Төрийн аудитын газраас “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлттэй үнэлэгдсэн.



## ӨРГӨДӨЛ ГОМДОЛ

Өргөдөл гомдлыг нээлттэй утас 98-970-970, өргөдөл гомдлын дэвтэр, санал хүсэлтийн хайрцаг, цахим хуудсаар хүлээн авч ажиллаж байна. Бүртгэлийн үйлчилгээг ИУБ-ийн онлайн санд шалгуулаагүйгээс иргэд буруу төлбөр тушаах, интернэтийн хурднаас шалтгаалж киоск машин гацаж баримт хэвлэхгүй тохиолдолд дахин тушаах зэрэг зөрчил удаа дараа үүссэн тул зөвлөгөө өгөх бүртгэгч нарыг хуваарийн дагуу ажиллуулж байна.


Иргэн, хуулийн этгээдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан 34 санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч тухай бүрт нь шийдвэрлэж хариу өгч ажилласан.



## СУРГАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Сургалтын ажлын хэсэг нь 2025 онд 3 бүлэг 11 нэр төрлийн сургалт зохион байгуулахаар төлөвлөгөө гаргаж, хэлтсийн даргаар батлуулан ажиллалаа.

ХЭЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ж.Ганзориг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 40 албан хаагч, сумын газрын даамлуудад зориулан “Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй ажил, анхаарах асуудал” сэдвээр, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ч.Энхцэцэг аймгийн 67 багийн Засаг дарга нарт “Улсын бүртгэлийн цахим шилжилт” сэдвээр, Иргэний улсын бүртгэгч М.Галбадрах Нийгмийн даатгалын газарт “Тоон гарын үсгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, хуулийн хэрэгжилт” сэдвээр, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Ууганчимэг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын Газар, Насан туршийн боловсролын төв, Амжилтын хөшүүрэг ТББ байгууллагатай хамтран гарааны бизнес эрхлэгч иргэдэд зориулсан “Шинээр хуулийн этгээд үүсгэн байгуулахад шаардлагатай бичиг баримтын бүрдүүлбэр”-ийн талаарх сургалтыг тус тус зохион байгуулж, нийт 149 иргэнийг хамруулсан.




Тайлант хугацаанд нийт 56 сургалт /бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 18 сургалт, албан хаагчдын хандлага, хариуцлага, ёс зүйн чиглэлээр 6, төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан болон хамтарсан сургалт-31, сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр 1 /-д давхардсан тоогоор 700 гаруй албан хаагч хамрагдлаа. Үүнд:



Мэдээлэл технологийн ажилтнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулагдсан “Зүүн бүсийн харилцаа холбоо, мэдээллийн технологи”-ийн чуулганд хэлтсээс 1 албан хаагч хамрагдлаа.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” сэдэвт зүүн бүсийн зөвлөгөөнд 2 албан хаагч хамрагдлаа.



Бүгд найрамдах Солонгос улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Койка/-ын санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол Улсын бүртгэлийн системийн чадавхыг бэхжүүлэх 2023-2025” төслийн 3 дахь удаагийн сургалтын арга хэмжээнд Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ч.Энхцэцэг хамрагдсан. Пусан хотод зохион байгуулагдсан “Олон улсын архивын зөвлөлийн зүүн азийн бүсийн салбар нэгдсэн чуулганд архивч С.Батчимэг хамрагдсан.



Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг хангах зорилгын хүрээнд дараах сургалт, арга хэмжээнүүдэд хэлтсийн албан хаагчид хамрагдлаа. Үүнд:

- Авлигатай тэмцэх газраас “Эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан” сургалт;
- Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалт;
- “Хөрөнгө, орлогын мэдүүлэг бөглөхөд анхаарах асуудал”-ын талаарх сургалт;
- Аймгийн Засаг даргын Тамгын газраас “Авлигаас урьдчилан сэргийлэх” сургалт;

## СУРГАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

### УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРААС ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан мэргэшил арга зүйгээр хангах, ур чадварыг нэмэгдүүлэх, арга зүйн сургалтуудад хамрагдлаа. Үүнд:

- Тус хэлтэст шинээр томилогдсон 3 албан хаагчийг чиглүүлэх, ажлын байранд дадлагажуулах сургалт;
- Мэдээлэл технологийн ажилтныг мэргэшүүлэх, сургалт;
- “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхөд нэгжийн удирдлагаас хэрэгжүүлэх арга хэмжээ, анхаарах асуудал”, “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ” сургалтад 1 албан хаагч;
- “Аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн иргэний улсын бүртгэл хариуцсан улсын (ахлах) бүртгэгчийг мэргэжил, арга зүйгээр хангах, мэдлэг, ур чадвар чадамжийг нэмэгдүүлэх сургалт”-д 2 албан хаагч;
- “Ажилтан, албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх Спорт-2025 нэгдсэн сургалт”-д давхардсан тоогоор 11 албан хаагч хамрагдлаа.
- Хууль зүйн, дотоод хэргийн салбарын санхүү, нягтлан бодох бүртгэлийн e-accounting.mojha.gov.mn систем дээр ажиллах чиглүүлэх сургалт






Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын Архивын хэлтсийн мэргэжилтэн Н.Баярмаа “Архив албан хэрэг хөтлөлтийн стандарт”-ын талаарх сургалтыг хэлтсийн нийт 28 албан хаагч нарт танхим болон цахим хэлбэрээр 2025 оны 04 дүгээр сарын 15–нд зохион байгууллаа.



Иргэний улсын бүртгэлийн тасгийн нийт 15 улсын бүртгэгч нарт “Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас лавлагаа олгоход нийтлэг анхаарах асуудал, бүртгэлийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх” сэдвээр танхим болон цахим хэлбэрээр давтан сургалтыг зохион байгуулав.



Хэлтсийн нийт албан хаагчид Удирдлагын академийн төрийн албан хаагчид зориулсан “Авлигаас ангид төрийн алба”, “Ёс зүй”, “Хүний эрх” цахим анхан шат, Монгол бичгийн анхан, дунд, ахисан түвшний сургалтад тус тус хамрагдаж, сертификат аван мэдлэг чадвараа дээшлүүлсэн.



## СУРГАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ёс зүйтэй хамт олон байх уриалгын хүрээнд хэлтсийн албан хаагчдад “Ёс зүйн” сургалтыг зохион байгууллаа.




Дорнод аймаг дахь Прокурорын газраас зөрчил шалгах шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын зөвлөгөөнд хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах эрхтэй 2 албан хаагч оролцсон..



Тусгай хэрэгцээт боловсролын багш Г.Содмаа хэлтсийн нийт албан хаагчдад дохионы хэлний анхан шатны сургалтыг зохион байгуулсан бөгөөд өдөр тутмын хэрэглээний дохионы хэлийг зааж сургалаа.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны А/1891 дүгээр албан бичгийн хүрээнд “Төрийн болон орон нутгийн өмч нэгдсэн цахим систем”-ийн программ хангамжийн сургалтад 3 албан хаагч хамрагдлаа.





## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

- Аймгийн ИТХурлын даргын 2025 оны 09 дүгээр сарын 29-н өдрийн А/10 дугаар захирамжаар байгуулагдсан “Аймаг орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сүм хийд шашны байгууллагуудын үйл ажиллагаанд хийх”;
- 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн захирамжаар байгуулагдсан Орон нутгийн хэмжээнд оршуулгын газар олгох, үйл ажиллагаа эрхлэх, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх;
- 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/372 захирамжаар “Аймгийн хүн ам орон сууцны 2025 оны завсрын тооллого хийх” ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллалаа.
- “НЭЭЛТТЭЙ УТАС – 7058-2233” дугаарын утас, “Иргэд хүлээн авах төв”-д аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, газар, хэлтсийн удирдах ажилтнууд 7 хоног бүрийн Пүрэв гарагт баталсан хуваарийн дагуу ажиллаж байна.



# СУРГАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Байгууллагын даргын баталсан “Улсын бүртгэлийн ерөнхий газрын дотоод хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөө”-ний дагуу 2025 оны 02 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд томилогдсон ажлын хэсэг хэлтсийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, үйл ажиллагааг сайжруулах, хариуцлага дэг журмыг, дээшлүүлэх зорилгоор байгууллагын даргаас 2025 оны 1/4410 дугаартай албан даалгаврыг ирүүлсэн. Албан даалгаврын төлөвлөгөө, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр 19/349 дугаар албан тоотор хүргүүлэн ажиллав.





## АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛЖ, ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ШИНЭЧЛЭЛЭЭ.

Хэлтсийн албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах, үйл ажиллагааны үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах техник хэрэгслүүдийг шинээр худалдан авч, ашиглалтад орууллаа. Үүнд:

- Ухаалаг дэлгэц – 1 ширхэг
- Принтер – 2 ширхэг (Үнийн дүн 6.558.000 төгрөг)



Улсын бүртгэлийн ерөнхий газраас албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор дараах тоног төхөөрөмжийг шийдвэрлэж өгсөн. Үүнд:

- Суурин компьютер - 2 ширхэг
- Принтер - 2 ширхэг
- Сканер - 1 ширхэг
- Зөөврийн компьютер - 3 ширхэг



Сумдын ЗДТГ-ын дэмжлэгтэйгээр Баяндун, Баян-Уул, Гурванзагал, Халхгол сумдад улсын бүртгэлийн зөөврийн 4G тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлсэн.



## СУРГАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

2025 оны улирал бүр зохион байгуулагддаг “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”-ын дагуу шалгалтад оролцогч иргэдийн бүртгэлийг хурууны хээгээр бүртгэж ажиллалаа.



Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтын ажиллагааны хүрээнд зөврийн тоног төхөөрөмж ашиглан гэрлэлтийн бүртгэл - 2, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл - 2 нийт 4 бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн. Мөн Дашбалбар сумын ЗДТГазартай хамтран иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-69, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр-17 нийт 86 иргэнд зөвлөгөө мэдээлэл хүргэсэн.





## АХМАД МЭРГЭЖИЛТНИЙ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСӨЛ

Дорнод аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газраас хэрэгжүүлж буй “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ”-ний төслийн хүрээнд

- Иргэний улсын бүртгэлийн архивын 1951-1960 оны цаасан баримтыг цахимжуулах чиглэлээр ахмад ажилтан З.Сарантуяа;
- Хяналт шалгалтын чиглэлээр ахмад ажилтан Л.Сугаррагчаа;
- Байгууллагын архивын үйл ажиллагаа, бичиг хэргийн стандартын чиглэлээр ахмад ажилтан Бямбацэцэг нар зөвлөх үйлчилгээ үзүүллээ.



## “АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХАД БИДНИЙ МАНЛАЙЛАЛ” СЭДЭВТ БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН НЭГДСЭН ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦЛОО.

Тус зөвлөгөөнөөр ИУБТДарга бөгөөд Улсын ахлах бүртгэгч Ч.Энхцэцэг Улсын бүртгэлийн цахим шилжилтийн талаар 14 сумын 67 багийн Засаг дарга нарт мэдээлэл өгч, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллалаа. Мөн “Танд хүргэх бүртгэлийн багц” гарын авлага бэлтгэн тараав..



# СУРГАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

## НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2025 онд нийт 5 удаагийн Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан бөгөөд 384 иргэн, 14 аж ахуйн нэгжид зөвлөгөө мэдээлэл, 290 иргэнд тоон гарын үсэг, шилжилт хөдөлгөөний бүртгэл, иргэний улсын бүртгэлийн лавлагаа, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ.



Сумдын малчдын зөвлөгөөн, багийн хуралд улсын бүртгэлийн үйлчилгээ болон зөвлөгөө мэдээллийг давхардсан тоогоор 1320 иргэнд хүргэж ажилласан.





## ИРГЭДЭД ЗӨӨВРИЙН ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЛЭЭ.

Зорилтод бүлгийн 11 иргэдийн гэрт очиж бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй үйлчилгээний орчин бүрдүүлэх зорилгоор харааны шил, томруулдаг шил, дараалалгүй үйлчлүүлэх тэмдэг зэргийг байршуулсан.

Зүүн бүсийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 12 ахмад настанд зөөврийн төхөөрөмжөөр иргэний бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ.

Матад суман зөөврийн тоног төхөөрөмж ашиглан 97 иргэнд бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ. Үүнд:

- Гадаад паспортын бүртгэл-12
- Тоон гарын үсэг олголт-70
- Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл-7
- Шилжилт хөдөлгөөний бүртгэл-2
- Төрсний гэрчилгээ дахин олгосон бүртгэл-1
- Лавлагаа-13



## ЭРҮҮЛ МЭНД

### И“ХАМГИЙН ЧУХАЛ НЬ” ЗОРИЛТОТ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГТ ХАМРАГДЛАА

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачилгаар салбарын хөдөө орон нутагт ажиллаж буй албан хаагчид болон тэдний гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийн дунд эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, өвчнийг эрт үед нь оношлох, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилго бүхий “Хамгийн чухал нь” зорилтот арга хэмжээ 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулагдлаа.

Тус арга хэмжээнд хэлтсийн 28 албан хаагч болон тэдний гэр бүлийн насанд хүрсэн 6 гишүүн, нийт 34 хүн хамрагдсан бөгөөд:

- Зүрх судасны өвчин
- Чихрийн шижингийн эрсдэлийг үнэлэх шинжилгээ
- Биеийн жингийн индекс
- Өөх тос, ус, яс болон булчингийн массын хэмжилт зэрэг үзлэгт хамрагдлаа.

Мөн мэдрэл, дотрын, мэс заслын болон сэтгэл зүйн чиглэлийн эмч нараас зөвлөгөө, мэдээлэл авлаа.

Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэгт зүү төөнүүр, бариа заслын өдрийн эмчилгээнд хэлтсийн албан хаагчид хамрагдлаа.



### УЛСЫН БҮРТГЭЛИЙН 85 ЖИЛИЙН ОЙГ УГТАН ДАРААХ ОНЦЛОГ АЖЛЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭЛЭЭ.

- Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Хэрлэн сумын Хан-Уул чиглэлд "ЭРЧ ХҮЧ - 2025" явган аялалыг зохион байгуулж, тайланг видео хэлбэрээр байгууллагын цахим хуудаст байршуулсан бөгөөд 2400 үзэлтэй байна.



- Монгол Улсын ерөнхийлөгчийн 2025 оны 44 дүгээр зарлигийн дагуу "ТЭР БУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН"-ий Чойбалсан хотын намрын мод тарих ажилд хамт олноороо идэвхтэй оролцож, Хэрлэн сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт 42 ширхэг улиас, байгууллагын төгөлд албан хаагчид гэр бүлийн гишүүдийн хамт Хэрлэн сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах байгууллагын хуваарьт талбайд 30 нарс, 20 улиас, 5 бургас нийт 55 ширхэг мод нэмж тарилаа.



## БУСАД

- 10 ДУГААР САРД ҮЙЛЧЛҮҮЛСЭН :

-шинээр төрсөн 13 хүүхэд

-гэр бүл болж гэрлэсний бүртгэлд бүртгүүлсэн 6 хосуудад


-хэлтсийн 10 дугаар сард төрсөн өдөр нь тохиосон 2 албан хаагчдад нарс, гацуур, агч мод бэлэглэлээ.



- Улсын бүртгэлийн байгууллага нь цахим шилжилтийг үе шаттайгаар хэрэгжүүлэн цаасан суурьт баримтыг багасгаж, иргэдийн цахим хэрэглээг нэмэгдүүлснээр иргэд цаг хугацаа орон зайнаас үл хамааран түргэн, шуурхай, чирэгдэлгүйгээр бүртгэлийн үйлчилгээг авах боломж нэмэгдсэн талаарх "Цахим бүртгэгч - цаасгүй бүртгэл" цахим контентыг бэлтгэн хүргүүлэв.



Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ойн арга хэмжээний х... See more





- Албан хаагчдын хүүхдүүдийн бүтээлч сэтгэлгээ, авьяас чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “УЛСЫН БҮРТГЭЛ” сэдэвт хүүхдийн гар зургийн уралдааныг зохион байгууллаа.



- Улсын бүртгэлийн байгууллагын брэндбүүкийн батлагдсан загвараар хэлтсийн мэдээллийн самбар, ханын хаяг, туг, өрөөний хаягжуулалт, албан хаагчдын ажлын үнэмлэх, цахим машины тэмдэглэгээ, тат түлх наалтыг тус тус шинэчиллээ.



## БУСАД

- Албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, хамт олны эерэг уур амьсгалыг бий болгох зорилгоор өглөө бүр дасгалын цагийг бий болгож, дугуйн аялал зэрэг спортын үйл ажиллагааг зохион байгууллаа.



## ХҮҮХДИЙН БАЯР


Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн "НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД" уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх зөвлөмжийн дагуу байгууллагын албан хаагчдынхаа хүүхдийн эрүүл мэндийг дэмжиж, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй бэлгийн багцыг хүүхэд бүрт хүргүүллээ.





## ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЗОРИЛГООР ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙЛЭЭ.

Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулж, эрүүл ахуйг сайжруулах, хүн амыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тус хэлтсийн албан хаагчид 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр хариуцсан талбай болох Хэрлэн голын ногоон бүсийг цэвэрлэв. Мөн Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Цэмцгэр Чойбалсан” төслийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа бүх нийтийн цэвэрлэгээнд 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр нэгдлээ.



## "ЗАД УГААЯ" АЯНД НЭГДЛЭЭ.

Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны А/307 дугаар “Цэвэр орчныг бүрдүүлэх тухай” захирамжийн хүрээнд хэлтсийн албан хаагчид “ЗАД УГААЯ” аянд идэвхтэй оролцлоо.

Энэхүү ажлын хүрээнд хэлтсийн албан хаагчид:

- Байгууллагын гадна талбайн хог хаягдлыг цэвэрлэх, зам талбайг шүүрдэх,
- Дотоод орчныг эмхэлж цэгцлэх, угааж ариутгах, эд хогшлыг зохион байгуулалттай байрлуулах ажлуудыг гүйцэтгэлээ.



## БУСАД

### ХҮМҮҮНЛЭГИЙН ҮЙЛСЭД НЭГДЛЭЭ.

Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд гарсан гал түймрийн улмаас хохирсон айл, өрхүүдэд туслах хандивын аянд нэгдэн, хэлтсийн зүгээс 600,000 төгрөгийн хандив өгч дэмжлэг үзүүллээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор “Бид чадна Эм Эн Нэгдэл” төрийн бус байгууллагаас гаргасан цуврал номын худалдааны аянд хэлтсийн бүх албан хаагч 100% идэвхтэй оролцож, нийт 531,000 төгрөгийн үнэ бүхий ном худалдан авч, үйл ажиллагааг дэмжлээ.



### АХМАДУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

Өндөр насны тэтгэвэрт гарсан 6 ахмад ажилтнуудад Олон улсын ахмад настны өдөр, сар шинийн баяраар хүндэтгэл үзүүлж уулзалт зохион байгуулдаг уламжлалтай. 2025 оны сар шинийн баяр болон олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан нийт 2,597,060 төгрөгийг Ахмадын сангаас зарцуулсан байна.





جمهوری اسلامی ایران

وزارت آموزش عالی